



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Empowered lives.
Resilient nations.

“БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ БҮХИЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН СҮЛЖЭЭ”

МОН/13/303 ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Монгол орны олон янз экосистемийн нэгдмэл байдлыг хангаснаар дэлхийн хэмжээнд ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийн оршин байх нөхцлийг бүрдүүлнэ

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

- Даян Дэлхийн Байгаль Орчны Сан - 1,309,091 \$
- НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр-200,000\$
- БОАЖЯ -500,000 \$ /бэлэн бус/

НИЙТ ТӨСӨВ:

1,509,091 сая ам доллар

ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ ГАЗАР НУТАГ:

| | | |
|---------------------------|---|------------|
| 1. “Гулзат” ОНТХГ | (Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумд) | 203,316 га |
| 2. “Хавтгар” ОНТХГ | (Хэнтийн аймгийн Батширээт сум) | 104,900 га |
| 3. “Түмэнхаан-Шалз” ОНТХГ | (Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-Уул, Хэнтийн аймгийн Норовлин сумд) | 374,499 га |

ТӨСЛИЙН ЗОРИЛТ:

Экосистемийн төлөөлөл нь тусгай хамгаалалтанд бүрэн хамрагдаагүй газруудад нутгийн иргэдийн хамгаалалттай газар нутгуудыг бий болгох замаар улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх явцыг эрчимжүүлнэ

ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:

2013-2018 он /5 жил/

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГАРСАН АМЖИЛТ, ҮР ДҮН:




Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн хэмжээг **600** орчим мянган га-р өргөтгөж экологийн коридор нутгийг байгуулав:

1

Улсын болон орон нутгийн хамгаалалттай газар нутгийг холбосон зэрлэг амьтны нүүдлийн экологийн **коридор нутгийг** баруун болон зүүн бүсэд үүсгэн байгуулж орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Үүнд:


а. 433,9 мян га **ЗҮҮН БҮСЭД**

Тосонхулстайн байгалийн нөөц газар, Онон Балжийн байгалийн цогцолборт газар хооронд цагаан зээрийн нүүдлийн болон төллөх нутаг, Дорнод, Хэнтий аймгийн Баян-уул, Цагаан-овоо, Норовлин сумын нутаг



б. 278.9 мян га **БАРУУН БҮСЭД**

Цагаан шувуут, Түргэний уулсын дархан цаазат газруудыг холбосон аргаль хониний нүүдлийн болон тархац нутаг, Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумын нутаг



Нутгийн иргэдэд түшиглэсэн менежментийн жишиг бүтэц, зохион байгуулалт бий болж, талуудын чадавхи бэхжсэн:

1

- Төсөл хэрэгжсэн 3 ОНХГ-т хамтын менежментийн дараах жишиг бүтэцийг бий болгон газар нутгийн хамгаалалтыг хангаж байна. Үүнд:
- Гулзат ОНХГ**-ыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хуулийн этгээд (Төрийн бус байгууллага)-д гэрээгээр хариуцуулан хамгаалуулах;
 - Хавтгар ОНХГ**-ыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хуулийн этгээд (Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар)-т гэрээгээр хариуцуулан хамгаалуулах;
 - Түмэнхаан-Шалз ОНХГ**-ыг одоогийн хүчин төгөлдөр хуулийн хүрээнд сумын засаг захиргаа хариуцан хамгаалж байна.



Дээрх 3 ОНТХГ-ын хамгаалалтыг үр ашигтай хэрэгжүүлэхэд зэргэлдээ орших улсын ТХГН-ийн хамгаалалтын захиргаад чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал, Гулзатад Увс нуурын ай савын ДЦГ, Хавтгарт Хан Хэнтийн ДЦГ, Түмэнхаан-Шалзад Дорнодын УТХГ, Онон Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаад менежментийг хариуцагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр хамтарсан судалгаа шинжилгээ хийх, идэвхтэн байгаль хамгаалагчдыг чадавхжуулах, мэдээллийн сан үүсгэх зэрэг ажлыг удирдан зохион байгуулж байна.

2 ОНХГ-ын хамгаалалтын менежментэд голлох үүргийг байгаль хамгаалах нөхөрлөлүүд гүйцэтгэдэг. Төсөл хэрэгжиж буй 3 ОНТХГ-т нийт **418 малчин өрхийн 1243 малчин 33 нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр** хариуцан хамгаалж буй бэлчээр нутгаа зохистой ашиглан биологийн олон янз байдалд учирч буй дарамтыг бууруулахад чухал хувь нэмэр оруулж байна. Тухайлбал, Түмэнхаан-Шалз ОНТХГ-ын 3 суманд гарсан **түймрийн тоо** 2015-2016 онд **40%**-иар, 2016-2017 онд **80%**-иар, **хулгайн ан** 2015-2016 онд 15%-иар, 2016-2017 онд 30%-иар буурсан байна.



3 Төсөл хэрэгжсэн 6 суманд албан ёсны гэрчилгээтэй **50 идэвхтэн байгаль хамгаалагч** ажиллаж, хариуцсан газар нутагтаа тогтоосон замналын дагуу мониторинг хийж байна. Төслийн зүгээс тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэхийн сацуу нэн тэргүүний шаардлагатай зарим багаж хэрэгсэл олгосон. Үүнд: 72% нь GPS багаж, 51% нь дуран, 32% нь зургийн аппарат, 20% нь мотоциклээр хангагдсан.



4 Аймаг, сумын түвшинд орон нутгийн тусгай хамгаалалттай газрын талаарх ойлголт, мэдлэг эрс сайжирч нэг түвшинд хүрсэн ба талуудын хамтын ажиллагаа улам бэхжсэн. Төслөөс холбогдох байгууллагуудад (БОАЖЯ; Хан Хэнтий, Онон Балж, Увс нуурын ай савын ТХГН-ийн хамгаалалтын захиргаад; Дорнод, Хэнтий, Увс аймгийн БОАЖГ, ГЗБГЗЗГ, ОБЕГ; төсөл хэрэгжиж буй 6 сумын ЗДТГ, Гулзат, Хавтгарын менежментийг хариуцагч байгууллага, 33 нөхөрлөл, 50 идэвхтэн байгаль хамгаалагч) нийт **280,3 сая** төгрөгний үнэ бүхий 52 төрлийн багаж, тоног төхөөрөмжийг байгаль хамгаалах үйлсэд зориулан олгов.



5 Төслийн хүрээнд бий болсон чадавхи, гарсан үр дүнг цаашид тогвортой авч явах, бэлчээр, зэрлэг амьтныг цогцоор нь хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Ногоон Алт хөтөлбөрийн “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо”-той хамтран дараах сумдад **“Итгэмжлэх сан”** байгуулсан: Хэнтий аймгийн Норовлин суманд **15,8 сая төг**, Дорнод аймгийн Баян-уул суманд **35,8 сая төг**, Цагаан-овоо суманд **25,9 сая төг**.




Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчинг сайжруулах талаар:

6 “ТХГН-ийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд ОНТХГ-ыг улсын ТХГН-ын сүлжээнд хамруулан, бүртгэл, зураглал, засаглал, менежментийн асуудлыг тусгайлсан дараах 2 журмаар зохицуулах заалтууд оруулж, эдгээр журмын төслийг боловсруулан БОАЖЯ-нд хүлээлгэн өгөв. Үүнд:

- a. “Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах журам”-ийн шинэчилсэн төсөл
- b. “Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментийг хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулах тухай журам” –ын төсөл /шинээр/
- c. “Газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах заавар”-ыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ)-тай хамтран шинээр боловсруулж тус газрын даргын 2017 оны 3-р сарын 16-ны өдрийн А/73 тоот тушаалаар баталсан.



ОНХГ болон нутгийн иргэдийн хамгаалалттай газрын мэдээллийн санг үүсгэн байгуулснаар салбар хоорондын мэдээллийн нэгдсэн систем бий болсон:




7 Байгаль орчны нэгдсэн онлайн мэдээллийн сан (<http://www.eic.mn>)-гийн хүрээнд дараах хоёр дэд мэдээллийн санг шинээр үүсгэн байгуулав. Үүнд:

- Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын нэгдсэн мэдээллийн сан (www.eic.mn/spalocal/) 2018 оны 6-р сарын байдлаар нийт **23,8 сая га** (улсын нийт газар нутгийн **15,2%**) бүхий 1373 газрыг аймаг, сумдын шийдвэрээр ОНТХ-нд авсан ба тус мэдээллийн сангийн мэдээ Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-ын Кадастрын мэдээллийн сантай нийцүүлэв.
- Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн нэгдсэн мэдээллийн сан (www.eic.mn/community/) 2018 оны 6 сарын байдлаар тус мэдээллийн санд нийт 21 аймгийн **1078** нөхөрлөлийн мэдээ ороод байна.



8 Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн веб хуудас www.nukhurlul.mn/ шинээр үүсгэн байгуулсан.

9 АМГТГ, ГЗБГЗЗГ, БОАЖЯ-ны хамтын ажиллагааны үр дүнд 2014-2017 оны хооронд газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан аймаг, сумдын тогтоолын **зөрчил 41 хувиар** буурч, улсын хэмжээнд орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ **11,0 сая га**-р нэмэгдсэн.

ОНХГ-ЫН ЗӨРЧИЛГҮЙ ТАЛБАЙ, %



ОНХГ-ЫН ЗӨРЧИЛГҮЙ МЭДЭЭ, ТОО



2018 оны 6-р сарын байдлаар ОНХГ-ын нийт талбайн хэмжээ 61,801,756 га, нийт мэдээний тоо 2598 байв.




ОНХГ-ын менежментийн үр ашигт байдал нэмэгдсэн:

10 Төсөл хэрэгжиж буй 3 ОНТХГ-ын менежментийн үр ашигт байдал суурь онтой харьцуулахад **35-58%**-р тус тус нэмэгдсэн.




✓ Түлхүүр зүйлийн тоо толгой өссөн:

11 Төсөл хэрэгжих хугацаанд Гулзат ОНТХГ-т аргалийн тоо толгой 30 орчим хувиар (1541-с 2000), Хавтгар ОНТХГ-т халиун буга, молцог хандгай, Түмэнхаан-шалз ОНТХГ-т тарвагны тоо толгой өсч, тархац нутаг тэлсэн.



✓ ОНХГ-ын тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх талаар:


- НҮБХХ-ийн БИОФИН төслийн хүрээнд Түмэнхаан-шалз ОНХГ-т тогтвортой санхүүжилтийн боломжит хувилбар болох махны өртгийн сүлжээний зардал, үр ашгийн тооцоог батгаасан бизнес төлөвлөгөөг боловсруулан, түүнийг хэрэгжүүлэх механизмыг тодорхойлох, хөрөнгө оруулагчдыг татах үйл ажиллагааг эхлүүлээд байна.
- Төслийн хүрээнд бий болсон чадавхи, гарсан үр дүнг цаашид тогтвортой авч явах, бэлчээр, зэрлэг амьтныг цогцоор нь хамгаалах хүрээнд тус төсөл, ШХА-ийн Ногоон Алт хөтөлбөр, сумын малчид гурван талаас ижил хэмжээний мөнгөн дүнг нийлүүлж 3 суманд **"Бэлчээр ашиглалтын хэсгийн дундын мөнгөн хуримтлалын сан"** байгуулав. Үүнд: Хэнтий аймгийн Норовлин суманд **15,8 сая төг**, Дорнод аймгийн Баян-уул суманд **35,8 сая төг**, Цагаан-овоо суманд **25,9 сая төг**. төвлөрсөн. Тус сангаас малчдын байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлэх, гишүүн өрхүүдэд жижиг зээл олгохоос гадна Идэвхтэн байгаль хамгаалагч нарын мониторинг, эргүүл хяналт хийх шатахууны зардал, урамшууллыг шийдвэрлэх юм.
- Мөн дээрх 3 сумын зарим нөхөрлөлийг тогтвортой ноос, ноолуурын өртгийн сүлжээнд хамруулснаар ноос, ноолуурын нэр хүнд бүхий компаниудын баталгаат нийлүүлэгч болохын сацуу энэхүү гэрээ нь бэлчээр, байгалиа хамгаалах, малын эрүүл мэндийг хангах хөшүүрэг болж өгөх юм. (Sustainable Fibre Alliance – Тогтвортой ноос ноолуурын эвсэл)
- Гулзат ОНХГ-ын санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болох спорт агнуураас орон нутгийн төсөвт орох хэмжээ төсөл хэрэгжих хугацаанд **70%-иар**, эргэн зарцуулалт **3,4 дахин** нэмэгдсэн.



ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРСАН ТЭРГҮҮН ТУРШЛАГА:



- 1.** ОНХГ-ын хамгаалалтын менежментийг **төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд** хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулж оролцогч талуудын (аймаг, сумын засаг захиргаа, ОНХГ-ын менежментийг хариуцагч хуулийн этгээд, аймгийн БОАЖГ, улсын ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, нөхөрлөлүүд) хамтарч ажиллах арга, механизмыг тодорхойлсноор **менежментийн үр ашиг дээшилж, төсөв хөрөнгийн оновчтой хуваарилалтыг хийх** боломжтой болсон. Тухайлбал, Хэнтий аймгийн БОАЖГ-ын 2018 оны төсөвт Хавтгар ОНХГ-ын нарийвчилсан агнуур зохион байгуулалтын төлөвлөгөөг хийхээр тусгасан.
- 2.** Улсын болон ОНХГ-ыг холбосон цагаан зээр, аргаль хонь, хар сүүлтий зэрэг томоохон газар нутгийг эзлэн нутагшдаг ан амьтдын нүүдлийн коридор нутгийг орон нутгийн хамгаалалтад авч, тэдгээрийн амьдрах орчныг **ландшафтын түвшинд хамгаалах** боломж бүрдсэн.
- 3.** ОНХГ-ын менежментийг хариуцагч хуулийн этгээдийн удирдах болон хяналтын зөвлөлийг дан ганц нөхөрлөлүүдийн төлөөллөөр бүрдүүлсэн нь нутгийн иргэдийн шийдвэр гаргах, төлөвлөх, хянах үйл явцад жигд оролцох, харин өмнө нь байсан аймаг, сумын удирдлагын хяналт тавих, бодлогоор дэмжих эрх, үүргийг тодорхой болгосон.
- 4.** ОНХГ-т амьдарч буй айл өрхийн 80-90 хувийг хамгаалалтын менежментэд оролцуулснаар 2 сумын малчдад байгалийн нөөц ашигласны **ашиг орлогоос тэгш хүртэх** боломжийг олгож, энэ нь эргээд тухайн нутгийг хамгаалах хөшүүрэг болж байна. Түмэнхаан-Шалз ОНХГ-ын 3 суманд гарсан **түймрийн тоо** 2015-2016 онд **40%-иар**, 2016-2017 онд **80%-иар**, **хулгайн ан** 2015-2016 онд **15%-иар**, 2016-2017 онд **30%-иар** буурсан.
- 5.** ОНХГ-ын **хамгаалалтын менежментэд зэргэлдээ орших улсын ТХГ-ын хамгаалалтын захиргаадыг татаж оролцуулсан** нь идэвхтэн байгаль хамгаалагч нарын мониторинг, судалгаа, эргүүл хяналт хийх чадавхийг бэхжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.
- 6.** Байгаль орчны санхүүжилт, төлөвлөлт, эрх зүйн талаар сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлгийг аймаг, сумын санхүү, аудитын нэгж, Төрийн сан, ИТХ-ын төлөөлөгч нарт шат дараатай хийснээр “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль” (2012 он), “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” (2014 он) зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирч, тухайлбал Гулзат ОНХГ-т агнуурын орлогын эргэн зарцуулалт 30 орчим хувиар өссөн.





ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРСАН СУРГАМЖ:



1.

Улсын ТХГН-ийн хилийн гадна орших олон улсад болон бүс нутгийн хэмжээнд чухал ач холбогдол бүхий экосистем, байгалийн нөөцийг **орон нутгийн тусгай хамгаалалтанд авах замаар** хамгаалалтыг хангах боломжит 3 хувилбарыг туршиж хэрэгжүүлсэн. Монгол улсын хэмжээнд 2018 оны 6 сарын байдлаар нийт 23,7 сая га (нийт газар нутгийн 15%) бүхий 1000 гаруй орон нутгийн тусгай хамгаалалттай газар байгаа билээ. (www.eic.mn/spalocal/) Үүнээс гадна 1078 байгаль хамгаалах нөхөрлөлийн нийт 4,7 сая га бүхий газар нутаг нөхөрлөлийн нэгдсэн онлайн мэдээллийн санд бүргэгдээд байна. (www.eic.mn/communitiy/) Цаашид газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах зорилго, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож, эдгээр газрын үнэлгээг хийх шаардлагатай. Эдгээр газар нутгийг Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны IV, V, VI ангилалтай дүйцүүлэн зорилго, шалгуурыг тогтоож, биологийн төрөл зүйлийг хамгаалах, амьжиргааг дээшлүүлэх гэсэн хос зорилтыг хангахад чиглэсэн менежментийн бодлогыг хэрэгжүүлэх.

Ингэснээр Монгол улсын мянганы хөгжлийн зорилтууд (*тусгай хамгаалалтад авсан газар нутгийн Монгол улсын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувийг 2015 онд 30 хувьд хүргэх, үүнээс 15 хувийг орон нутгийн тусгай хамгаалалттай газраас бүрдүүлэх*), Ногоон хөгжлийн бодлого (*байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувьд хүргэх*), ТХГН-ийн үндэсний хөтөлбөр (*Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үдсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ*)-ийн хэрэгжилтийг хангах боломжийг бүрдэх юм.

2.

БОАЖЯ, АМГТГ, ГЗБГЗЗГ байгуулсан Санамж бичгийн хүрээнд тус тусын үүргээ биелүүлэх талаар анхаарч, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын мэдээ, мэдээллийн нэгдмэл байдлыг хангах

3.

Улсын тусгай хамгаалалттай газар хооронд, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар хооронд холбоос, коридор үүсгэн байгуулснаар зэрлэг ан амьтны нүүдэллэн шилжих нөхцлийг хангах, биологийн олон янз байдлыг хамгаалах дасан зохицох арга хэлбэр юм.

4.

ОНХГ-ын менежментийг хариуцагч хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг дүгнэх, үнэлэх механизм тодорхой байх шаардлагатай. Үүнд:

- гэрээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож гэрээний салшгүй хэсгээр авч үзэх;
- менежментийг хариуцагчийн хэнд, хэзээ тайлагнах талаар гэрээнд тодорхой зааж өгөх;
- гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэж, гэрээг сунгах, цуцлах талаар албан ёсны шийдвэр гаргаж менежментийг хариуцагчид мэдэгддэг байх

5.

Байгаль хамгаалах нөхөрлөлүүд нь менежментийг хариуцагч хуулийн этгээдэд гишүүнчлэлийн эрхтэй, тухайн хуулийн этгээдийн шийдвэр гаргах дээд бүтэц болох Удирдах зөвлөл/хороог бүрдүүлэх

6.

ОНХГ-ын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, төлөвлөгөөнд тодорхойлсон зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэхэд хамтын оролцооны аргаар 2 жилд нэг удаа үнэлгээ хийх ("*Хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээ*" МОН-МЕТТ аргаар)

7.

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үндсэн санхүүжилт нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах" журмаар зохицуулагдаж байдаг. Тиймээс эдгээр хууль тогтоомжийн талаар, мөн байгаль орчны төлөвлөлт, санхүүжилтийн талаарх ойлголт, мэдлэгийг сум, аймгийн иргэдийн хурлын төлөөлөгч, төсөв, санхүүгийн албан хаагч нарт түгээх;

8.

Спорт агнуурын квотыг шинжлэх ухааны үндэстэй тогтоож, агнуурын компаниудын сонгон шалгаруулалтад нөхөрлөл, менежментийг хариуцагчийн саналыг давуу эрхтэйгээр үндэслэн нээлттэй, онлайн хэлбэрээр явуулах, аргаль хонины лицензийн тарифыг олон улсын зах зээлийн үнэлгээтэй нийцүүлэх, аргалийн агнуурыг байгаль хамгаалах хэрэгсэл болгох талаар холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох.

9.

ТХГН-ийн болон ОНХГ-ын хамгаалалтын менежментийг тогтвортой хэрэгжүүлэх үндсэн нөхцөл нь тогтвортой санхүүгийн эх үүсвэртэй байх явдал юм. Тиймээс цаашид улсын төсвөөс өөр эх үүсвэрийг эрэлхийлж, тухайн нутгийн байгалийн нөөцөд түшиглэсэн хамгийн ашигтай байх бизнесийг дэмжин хөгжүүлж, тухайн бизнесийн менежментийн зардалд хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын зардлыг оруулах боломжтой.

Судалгаанд хамрагдсан ан амьтад

| Амьтны нэр | Хамгааллын статус | УТХГН-т хамрагдаагүй % | | Уул уурхайн лицензийн талбайн эзлэх % | |
|----------------|--|------------------------|----------------|---------------------------------------|----------------|
| | | Тархац нутгийн | Голомт нутгийн | Тархац нутгийн | Голомт нутгийн |
| Аргаль хонь |    | 73.1 | 52.6 | 12.3 | 8.0 |
| Халиун буга |   | 67.8 | 51.2 | 3.1 | 1.5 |
| Бор гөрөөс |   | 73.2 | 54.3 | 3.0 | 2.0 |
| Баданга хүдэр |    | 57.3 | 41.8 | 2.3 | 1.6 |
| Молцог хандгай |   | 31.6 | 10.1 | 2.0 | 1.0 |
| Зэрлэг гахай |   | 58.4 | 28.4 | 3.0 | 2.3 |
| Цагаан зээр |    | 88.3 | 83.2 | 9.0 | 7.3 |
| Цэн тогоруу |      | 75.9 | 76.4 | 14.2 | 2.0 |



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр - www.undp.mn

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар - www.mpa.gov.mn



**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**



Empowered lives.
Resilient nations.

“БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ БҮХИЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН СҮЛЖЭЭ”

МОН/13/303 ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Монгол орны олон янз экосистемийн нэгдмэл байдлыг хангаснаар дэлхийн хэмжээнд ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийн оршин байх нөхцлийг бүрдүүлнэ

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:

- Даян Дэлхийн Байгаль Орчны Сан-1,300,000 \$
- НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр-200,000\$
- БОАЖЯ -500,000 \$ /бэлэн бус/

НИЙТ ТӨСӨВ:

1,5 сая ам доллар

ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ ГАЗАР НУТАГ:

| | | |
|---------------------------|--|----------------|
| 1. “Гулзат” ОНТХГ | (Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумд) | 215.9 мян. га |
| 2. “Хавтгар” ОНТХГ | (Хэнтийн аймгийн Батширээт сум) | 104.9 мян.га |
| 3. “Түмэнхаан-Шалз” ОНТХГ | (Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-Уул, Хэнтий аймгийн Норовлин сумд) | 348.03 мян. га |

ТӨСЛИЙН ЗОРИЛТ:

Экосистемийн төлөөлөл нь тусгай хамгаалалтанд бүрэн хамрагдаагүй газруудад нутгийн иргэдийн хамгаалалттай газар нутгуудыг бий болгох замаар улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх явцыг эрчимжүүлнэ

ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:

2013-2018 он /5 жил/